



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот

“Хай Би Ойл” ХК-ийн хаалттай хүрээнд  
нэмж гаргах энгийн хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 25, 42 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 17.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хай Би Ойл” ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргах нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 42,884,686 /дөчин хоёр сая найман зуун наян дөрвөн мянга зургаан зуун наян зургаа/ ширхэг энгийн хувьцааг бүртгэн тус компанийн нийт гаргасан хувьцааг 52,118,954 /тавин хоёр сая нэг зуун арван найман мянга есөн зуун тавин дөрөв/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т үүрэг болгож, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Хай Би Ойл” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчдэд 343 төгрөгөөс доошгүй үнээр тэргүүн ээлжинд худалдан авахыг хуульд заасан журмын дагуу санал болгон зохион байгуулж, гүйцэтгэлийг Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэхийг “Хай Би Ойл” ХК /Ө.Хүдрээ/-д үүрэг болгосугай.

3. “Хай Би Ойл” ХК нэмж хувьцаа гаргасантай холбоотойгоор компанийн хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхийг 343 төгрөгөөс доошгүй үнээр хэрэгжүүлэх арга хэмжээг Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг ажлын 10 хоногийн дотор тус Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэхийг “Хай Би Ойл” ХК /Ө.Хүдрээ/-д үүрэг болгосугай.

4. “Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцааг хавсралтад заасан нэр бүхий иргэд, хуулийн этгээдэд тэдгээрийн компанид олгосон зээлтэй хувь дүйцүүлэн эзэмшүүлж, өмчлөх эрхийг баталгаажуулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д зөвшөөрсүгэй.

000894

5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь тогтмол хүргүүлж, хууль тогтоомж, Хорооны 2010 оны 234 дүгээр тогтоолоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Хай Би Ойл” ХК /Ө.Хүдрээ/-д үүрэг болгосугай.

6. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ /-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

Хорооны 2015 оны ..... дугаар тогтоолын Хавсралт

Д/д	Нэр	Хөрвөх хувьцааны тоо	Дүйцүүлэх хувь
1	Hutch Okamoto	159,174	0.371
2	Thracian property group	79,047	0.184
3	Richard L.Steele	2,094,448	4.884
4	Salman Al-Rashid	1,587,376	3.701
5	GF Select Equity fund	1,237,682	2.886
6	Laurence Lavelle	123,311	0.288
7	Nick Cousyn	247,677	0.578
8	Firebird Mongol Holding S.A.R.L	8,282,051	19.312
9	Passin management limited partnership	249,976	0.583
10	Hermes petroleum berhad	17,327,908	40.406
11	Т.Энхтуул	160,754	0.375
12	Т.Булгантуул	160,754	0.375
13	“Бидисек ҮЦК” ХК	1,812,528	4.227
14	Ш.Бүүвэйбаатар	1,044	0.002
15	Ж.Ганбаатар	10,702	0.025
16	Б.Үнэнсайхан	2,072	0.005
17	Д.Батсүрэн	165,118	0.385
18	Д.Ихтөгөлдөр	89,371	0.208
19	Д.Даянбилгүүн	155,953	0.364
20	Д.Дайчинбаатар	89,371	0.208
21	Д.Тэнүүн	89,371	0.208
22	Firebird global master holdings 2 S.A.R.L	4,167,934	9.719
23	Triton energy limited	4,167,934	9.719
25	Ө.Хүдрээ	423,130	0.987
	НИЙТ	42,884,686	100